

XX ЗУУНЫ МОНГОЛ ЯРУУ НАЙРГИЙН ТУУРВИЛЫН ОНЦЛОГ ХЭДЭН ЗҮЙЛ

Д. Сумьяа *

Монгол яруу найраг дэлхийн оюун билгийн их далайн нэгэн цутгал билээ. Энэ ундарга цагийн цагт оргилж хүмүүн төрөлхтнөө яруу түрлэг нэмсээр иржээ. Явсан замдаа татраагүй монгол яруу найргийн түүхийг зуун зуунаар товчоолбол, XIII-XIV зуунд агуу их Чингис хаан, түүний эзэнт их гүрний сүр хүчнийг бишрэн дуулсан шүлэг зохиол түрж, XIV зуунд бурханы шашны дунд үеийн дэлгэрэлт болж номч Чойжи-Одсэрийн орчуулга, шүлэг зохиол тодорхой байр эзэлж уламжилж ирсэн байна. XV-XVI зуунд монголчуудын өвөр зуурын зөрчил, хурсан их хүчний сарнил бутралыг тусгасан зохиол давамгайлж, XVII-XVIII зуунд үндэсний ухамсар сэргэснээр олон түүхэн сурвалж бичгүүд зохиогдож, бурханы шашны хожуу үеийн дэлгэрэлтийн нөлөөнд сургаалын болон шашны үзэл баримтлал бүхий зохиол зонхилжээ. XIX зуунд үндэсний ухамсар идэвхжиж, шүүмжлэлт аяс илүү нэвтрэв. Олон зохиолчид монгол болон төвд хэлээр зохиол туурвиж, бүддийн гүн ухааны болон сургаал шүлэг, яриа, үг зохиол, намтар зэрэг төрөл зүйл давамгайлж байв. Энэхүү түүхэн хөгжлийг хураангуйлан Монголын эртний уран зохиол гэж нэрлээд XX зуун гарснаас хойших зохиолыг Монголын орчин үеийн уран зохиол гэж нэрлэдэг.

Орчин үеийн уран зохиолоо мөн арван жилээр товчоолвол, 1920-оод онд гадаадын түрэмгийн эрхшээлээс эх орноо чөлөөлөх, ардын хувьсгалын уухайг түрсэн шүлэг зохиол давамгайлж, 1930-аад онд дотоодын үймээнийг намжаах, улс орны дотоодоо төвшитгөхөд, 1940-өөд онд хойч үеэ эх оронч баатарлаг үзлээр төлөвшүүлэх дуу болж, 1950-аад онд бүтээн байгуулах хөдөлмөрч үйлсийг үзүүлсэн зохиол голлон бичиж байв. 1960-аад онд үндэсний шинэ сэхээтний давхрага бүрэлдэж улмаар тусгаар монголоороо бахархах, 1970-аад онд социалист хөгжлөө бататган бэхжүүлэх үзэл зорилго дэвшүүлж, 1980-аад онд дэлхий дахины шинэлэг үзлийн уур амьсгал нэвтрэн, бүхнийг зүй тогтолт хөгжил хөдөлгөөнд нь авч үзэх чиг хандлага идэвхжиж, 1990-ээд оноос урлаг уран сайхны олон урсгал чиглэл, үзэл баримтлал утга зохиол, яруу найрагт чөлөөтэй дэлгэрч эхлэв.

Монгол уран зохиол уран сайхны сэтгэлгээний нь ийм олон үе шат, арвин өв санг бүтээжээ. Энэ өв сан буюу өнгөрснөө судлах гэдэг хуучнаас шинийг нээн олж хараад шинийг бүтээхэд оршино. Түүнээс хуучныг давтах, дагаж хуулбарлахад биш юм. Чөлөөтэй сэтгэлгээ дэлгэрсэн энэ цагт зарим хүмүүс XVI зуунаас хойших монголын

* ШУА, Хэл зохиолын хүрээлэн

утга зохиолыг Энэтхэг, Төвдийн хуулбар эсвэл зөвхөн шашны номлол сургаал байсан гэж үзэх, Монголын орчин үеийн уран зохиолыг ганц социалист үзлийн хүлээст хэв загвар байсан мэтээр хэтийдүүлж, уран сайхны ололт амжилтыг дээр өгүүлсэн хоёр зүйл алдуугаар хаан орлуулж байх нь заримд харагддаг.

Монгол яруу найргийн түүхэнд ХХ зуун аль ч талаараа өвөрмөц онцлогтой үе мөн. Монголын орчин үеийн яруу найраг эхнээсээ өнөөдрийг хүртэл уран сайхны сэтгэлгээний түүхэнд урьд өмнө тохиож байгаагүй дэндүү хөдөлгөөнтэй, олон талтай, сонирхолтой тийм түүхийг бичжээ¹. Өөрөөр хэлбэл Монголын орчин үеийн яруу найраг бараг цоо шинээр дахин мэндэлж, асар их үсрэнгүй хөгжилт, амжилтаар дүүрэн ирэв. Яагаад “бараг цоо шинээр дахин мэндэлсэн” гэхээр дорно дахины яруу найргийн уламжлалт хөрсөн дээр Орос Зөвлөлтийн утга зохиол, түүгээр дамжсан өрнийн утга зохиол, уран сайхны шимээр тэжээгдсэн уран сайхны сэтгэлгээгээр сэлбэгдэн төлжиж, цэцэглэн хөгжсөн шинэ яруу найраг байв.

Орос Зөвлөлтийн утга зохиолоор дамжсан гэдэг нь Европын дахин сэргэлт, соён гэгээрүүлэх зэрэг дэвшилтэт сэтгэлгээний давалгаа нь XIX зууны сүүл үеийн Орос оронд ирж суужээ. Иймд оросын утга зохиол бол дэлхийн утга зохиолын дэвшилтэт сэтгэлгээний ололтыг хүртэж, тэр боловсрол дээрээ хөгжсөн билээ. Иймд дэлхийн уран сайхны сэтгэлгээ, соёлын нэгэн том цөм болсон Орос Зөвлөлтийн утга зохиол нь дорно дахины соёлын гүн шим хөрстэй манай урлаг уран зохиол, тэр тусмаа яруу найрагт энэ зуунд шинэчлэл хийх нөхцлийг бүрэлдүүлж, хөгжилд чухал нөлөө үзүүлсэн юм. Энэ амжилт бол монгол үндэсний соёлын өв дээр “Манай орчин үеийн яруу найргийн суурийн чулууг туйлын зөв, бат бэх, маш ирээдүйтэй тавигдсанд”² оршино.

Монголын орчин үеийн яруу найраг бүтэн зууны шахам хөгжлийн замд заримдаа нэлээд бэрхшээлийг даван туулж, бас өөрийн үндэсний өвөрмөц онцлог амжилтыг олсоор Монгол яруу найраг гэж танигдах болтлоо бэхжиж дэлхийн яруу найргийн хөгжилтэй хөл нийлүүлэн хөгжиж ХХI зууны босгоор оров. ХХ зуун буюу Монголын орчин үеийн уран зохиол, яруу найраг нь

- Аман зохиолоос бичгийн уран зохиолд шилжиж буй
- Бурханы шашны болоод баатарлаг туулийн хийсвэрлэл, бясалгал хэтрүүллийн арга барилаас реалист арга зарчимд шилжсэн
- Дорно дахины сэтгэлгээний шим хөрсөнд Орос, Европын арга барилыг суулгасан
- Сонгодог нүүдлийн соёлоос суурин ахуй соёлд шилжиж буй

ийм олон завсар зааг үеийн шилжилт, сэтгэлгээний уулзвар дээр огцом эрс эргэлт бүхий цоо шинэ гэж болох түүхэн туурвилын зам туулж иржээ³.

¹) ХХ зууны Монголын яруу найргийн хөгжлийн төлөв, чиг хандлага. Монгол улсад зохиолчдын байгууллага үүсч байгуулагдсаны 80 жилийн ойд зориулсан “ХХ зууны монгол уран зохиол” эрдэм шинжилгээний хурал. Г.Мэнд-Ооёо, А.Мөнх-Оргил нарын хамт. Д.Сумъяа. “Монголын орчин үеийн яруу найраг-1. Хөгжлийн түүх” 2009. 5-рт

²) Бэгзийн Явуухулан. 1960-аад он хүртэлх манай яруу найраг, цаашид тавих зорилгын асуудалд. Түүвэр зохиол II. 1990 он. 9-рт

³) Сумъяа Д. “Судар бичгийн хүрээлэнгийн 90, Хэл зохиолын хүрээлэнгийн 50 жил, Судар бичгийн хүрээлэнгийн анхны эрдэмтэн нарийн бичгийн дарга Жамсраны Цэвээний 130

Ийм нүүдлийн соёлоос суурин ахуйн соёл руу шилжиж буй шилжилтийн үеийн ХХ зууны монгол найргийн уран сайхны сэтгэлгээ нь монголын уран зохиолын түүхэнд төдийгүй ерөөсөө нийт уран сайхны сэтгэлгээний түүхэнд жинхэнэ нүүдэлч монгол малчин, хүн байгалийн шүтэлцээт холбоо, байгалилаг сэтгэл оюуны дуулал бүхий нэг хэсэг уран бүтээл авчирснаараа үнэтэй зурвас үе байж болох юм⁴.

Өнөөдөр монголчууд нүүдэлчин байхаа аль эрт больсон байна. Бид үндсэндээ суурьшжээ. Нүүдэлчний ахуй болоод сэтгэлгээнээс холдсон суурин ахуйн өнөөгийн зохиол бүтээлээс түүнийг нэхэж, бас эрж хайх боломжгүй. Тэгэхлээр тэрхүү нүүдэлчний тухай, хөдөөгийн тухай, байгалийг сэтгэл зүрхээрээ мэдэрсэн тийм уран бүтээл дахиад үл давтагдах ч байж болох.

ХХ зууны хоёрдугаар хагас нь монголчуудад соёл иргэншлийн хувьд огцом эргэлтэй үе байв. Дан ганц уламжлалт сонгодог нүүдлийн соёл иргэншил бүхий монголчууд энэ үед атар газар эзэмшиж, аж үйлдвэржиж, хот суурин олноор бий болж, хүн зон төвлөрч суурин ахуй соёлд эрчимтэй шилжиж эхлэв. Энэ соёлын их хувьсал өөрчлөлт нь уран зохиолд тод тусгалаа олов. Тиймээс энэ цаг үед өсөж төрсөн нутгаа санагалзаж, бага насаа дурссан, хөдөөгийн тухай шүлэг зохиол маш ихээр гарав. Энэ шүлгүүдэд хамгийн гэгээн гэрэлт тунгалаг цаг мөч, эвдрээгүй эгэл хүний мөс чанар, онгон байгаль, орь гэгээн хүсэл тэр бүхэн бага настай нь цуг тэртээ цэнхэр алсад үлдсэн мэт дурссан, тэмүүлж дуудсан. Гэвч тэр ахуй, цагтаа буцаад очъё гэхнээ хот орон газар суух болсон хувь тавилангийн эрх хүлээсэнд ч юмуу, боломжгүй болсон ийм зохиол олноор бичигджээ.

Энэ нь **нэгд**, уран бүтээлч өөрийн хамгийн сайн мэддэг зүйлийн тухай сайн бичдэгтэй холбоотой. **Хоёрт**, нүүдэлчний ахуйгаас монгол хүн салж, суурин соёлд шилжиж буйтай холбоотой. Нэг соёлоос нөгөө соёлын хүрээнд, нэг ахуйгаас нөгөөд шилжиж буй ахуйн болон сэтгэлгээний өөрчлөлтөд үүссэн үзэл юм. Аливаа шинэ зүйлийг хүмүүс олзуурхаж бас шүүмжилж хүлээн авдаг. Тиймээс байгалиасаа хэт хамааралтай нүүдлийн ахуй соёл нь үгүй болох тусам түүнийгээ суурин соёл иргэншил дундаас нэхэж, тэр нь байгалийг зүрх сэтгэлээсээ дуудаж дуулсан шүлэг зохиол болж гарсан бас нэг учир байна.

ХХ зуунд Монгол уран зохиол, үзэл санаа, уран сайхны сэтгэлгээний хувьд эрс шинэчлэгдэж, дундад зууны бүс нутгийн уран зохиолын хүрээнээс хальж, орчин үеийн дэлхий дахины уран зохиолын төвшинд хүрч, уламжлалаа хадгалахын зэрэгцээ, реализмын туурвил зүйн арга барилыг баттай эзэмшиж, модернист дэг чиглэлийн сонирхолтой эрэл туршилтыг хийн, орчин үеийн дэлхийн уран зохиолын адил төрөл зүйл, жанраар туурвихаас гадна, хэлбичгийн шинжлэх ухааны нэгэн салбар уран зохиол судлалын иж бүрэн тогтолцоог бий болгож, хэрэгжүүлсэн энэ түүхэн цаг үе⁵-ийн яруу

жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал” “Монгол уран зохиолын дээж бичиг” номын тайлбар өгүүлэл илтгэл 2011.10.06-09.

⁴) Сумъяа Д. “Монголын орчин үеийн яруу найраг-II” “Огтлолцохуйн проекцоос Урианхайн сэрэхүй” 2009 он. 122-рт.

⁵) Монголын орчин үеийн уран зохиолын алдаа онооны дэнс. С.Байгалсайхан, Б.Мөнхбаяр нарын Монгол улсад зохиолчдын байгууллага үүсч байгуулагдсаны 80 жилийн ойд зориулсан “ХХ зууны монгол уран зохиол” эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл. “Монгол уран зохиолын дээж” 2011. 160-рт.

найраг нь уран сайхны сэтгэлгээний түүхэнд нэгэн өвөрмөц дүрслэл, сэтгэлгээг үлдээсэн байж болох юм.

Тиймээс ХХ зууны монгол яруу найргийн **гол онцлог нь** сонгодог нүүдлийн соёлоос суурин ахуй соёл шилжиж буй шилжилтийн үеийн яруу найраг байжээ гэж болох юм. Өөрөөр хэлбэл хөдөөг дуулсан шүлэг давамгайлсан аястай ч, орчин цагийн хотожсон шинэ иргэншлийн дуу хоолой бүхүй нүүдэл суурьшлын хосолмол яруу найраг байжээ. Ингэхдээ өмнө үеэсээ уран сайхны сэтгэлгээний олон дүр дүрслэл сэдэв агуулга уламжилж, шинэ ахуй, шинэ арга барилаар баяжин хөгжсөн байна. Тухайлбал:

Монголын эрт болоод эдүгээгийн яруу найрагт **хамгийн их уламжлалтай сэдэв бол дөрвөн улирлын** сэдэв байна. Ихэнх яруу найрагчид энэ сэдвээр бичжээ. Зарим нь 4 улирлаар, зарим нь нэг улирал, зарим нь 2 улирлын байдлыг өөрийн уран санаа, урлах арга барилаараа бичжээ. Тухайлбал зөвхөн дөрвөн улирлын өнгө байдлаар С.Буяннэмэхийн “Цаг үе ба амьдарлага”, Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг”, Д.Содномдоржийн “Дөрвөн улирал”, Д.Пүрэвдоржийн “Дөрвөн цагийн тал”, Л.Дашнямын “Дөрвөн улирал нэгэн сэтгэл” Д.Нямсүрэнгийн “Дөрвөн цаг”, Г.Мэнд-Ооёогийн “Он цагийн хүрд”, Ц.Бавуудоржийн “Дөрвөн улирал”, Б.Галсансүхийн “Постмодерн дөрвөн улирал” зэрэг цаг үеэ тусгасан янз бүрийн өгүүлэмжтэй шүлгийг нэрлэж болно. Гэхдээ дөрвөн улирал бичсэн шүлэг болгон сонгодог сайн болж яруу найргийг баяжуулдаггүй.

Учир нь дөрвөн улирлын шүлэг зохиол нь байгалийн хувьсан өөрчлөгдөх жам байдал дээр суурилан хүний нас амьдралын тухай гүн гүнзгий уран яруу санааг илэрхийлдэг байна. Дөрвөн улирлын монгол яруу найраг нь

- Одон гариг эрхисийн жам ёс
- Дэлхий ертөнцийн жам ёс
- Хүмүүн чанарын жам ёс
- Нийгмийн чанарын жам ёсон - гэсэн ийм дөрвөн жам ёсны тухай гүн уран санаа өгүүлдэг⁶ байна. Өөрөөр хэлбэл энэ дөрвөн жам ёсны хэдийг нь хэрхэн агуулснаараа уул шүлгийн сонгомол чанар, туурвил, уран гүн санааны жин багтаамж илэрхийлэгддэг тал байна. Жишээ нь Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг” шүлэгт

Холхи нар ойртож, хасын цасан хайлахад (одон гариг эрхэс)
Хуучин дэлхий хасагдаж хамаг юм шинэднэ (бөмбөрцөг дэлхий, хөрст эх газар)
Хөхөрсөн модон цэцэглэж, хүүхэд багачууд наадахад (хүмүүн чанар)
Хөгшин хүн өөрийгөө залуу болсон шиг санана. (нийгэм, бусадтай харьцах)

гээд дараагийн бадагт “Мөнх тэнгэрийн дор...” гэж мөн ийм чанаруудыг багтаажээ.

Б.Нямсүрэнгийн “Дөрвөн цаг” шүлэгт
Хаврын өглөө эрт босох сайхан(замбутив)

⁶⁾ Д.Сумъяа “Монголын орчин үеийн яруу найраг-II. Дөрвөн улирал, монгол яруу найраг хоёр”. 2009. 47-рт

Хазаар аваад моринд явах сайхан(хүний чанар жам ёс)
Сэрүүн цас үнэртэх нь сайхан (замбутив)
Сэмжин мөснөөс нь хүлхэх сайхан (хүний чанар жам ёс)

гэж урин хавар айсууг, дулаан улирал ирж байгаа учир өөдөөс цасны үнэр сэнгэнэж, цас саравчилж, тэр мөснөөс хүлхэхэд сэрүү татах сайхны мэдрэмжийг гаргажээ. Өөрөөр хэлбэл замбутивийн амьдралын жам ёсны сайхныг өгүүлж, тэр нь хүний мөс чанарын жам ёсонтой нийлж нийцэж буйг дуулснаараа тансаг гоо сайхны орь илэрхийлэл болжээ.

Энэ сэдэв бол монгол яруу найрагчдын ур ухаан уянга туурвилын хүч чадлыг шалгах нэг хэмжүүр ч гэж болох юм.

Энэ үеийн яруу найрагт “**Эх орон**”-ны сэдэв тогтон бүрэлдэж өөрийн бүхэл бүтэн хэв шинжээ бүрдүүлжээ. Эх орныхоо тухай бичээгүй яруу найрагч үгүй. Монгол яруу найргийн түүхээс үзэхүй “Эх орон”-ны сэдэв нь бараг Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлэг хүртэл өөр өөрсдийн өсөж төрсөн нутгаа илэрхийлж байв. Миний хорчин, миний буриад, миний Талын таван толгой гэх зэргээр дуулж иржээ. Харин ХХ зуунд “Миний эх орон” гэсэн үг, ойлголт энэ үеийн гол сэдвийн нэг болж, энэ сэдвээр олон сайхан шүлэг зохиол гарчээ. Эх орон гэсэн нэг сэдвийн дор уран сайхны элдэв эрэл хайгуулыг багтааж байв. Д.Нацагдоржийн “Миний нутаг”, Б.Явуухулангийн “Би хаана төрөв өө”, Д.Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол”, Ш.Сүрэнжавын “Монголын сайхан орон” сонет цэцгэн эрхи, Ж.Бадраагийн “Халуун элгэн нутаг”, П.Бадарчийн “Есөн эрдэнийн орон” ба Д.Цоодолын “Нутгийн зургаан өнгө”, Б.Лхагвасүрэнгийн “Боржигоны бор тал”, Д.Урианхайн “Эх орны тухай бодол”, Д.Нямсүрэнгийн “Дөрвөн цаг”, Ц.Бавуудоржийн “Монголын их амар амгалан” зэрэг олон шүлэг гарчээ. Эдгээр шүлгүүдийн өөр өөрийн шинэлэг нээлт ололтыг судлаачид нээн шинжилсэн⁷ байна.

Буддын гүн ухааны үзэл баримтлал орчин үеийн яруу найрагт хоёр байдлаар уламжлан ирсэн⁸ байна. Нэгд, өнөөгийн бидний ахуй соёл, сэтгэлгээ, сэтгэлгээний далд хөлөөр уламжлагджээ. Нөгөө нь, ялангуяа 1990-ээд оноос хойш шууд ухамсартайгаар хөгжүүлж ирсэн байна.

Сэтгэлгээний далд хөлөөр уламжилсан гүн ухааны жишээ шүлэг олон. Тухайлбал, Д.Нацагдорж, Б.Явуухулан нарын “Энэтхэг бүсгүй” шүлэг, О.Дашбалбарын “Амьддаа бие биеэ хайрла” зэрэг ил болоод далдаар бүддийн гүн ухааны үзэл шингэсэн тод илэрхийлэлтэй шүлэг олон байна.

1990-ээд оноос хойш шууд ухамсартайгаар оруулж ирсэн учир шалтгаан нь нэгд, оюуны гоо сайхны шинэ эрэлтэй холбоотой. Хоёрт, тухайн нийгэм цаг үеэс үүдэн нийт ард түмнийг соён гэгээрүүлэх арга замыг хайсантай холбоотой⁹. Жишээ нь О.Дашбалбарын “Бурханы мэлмий” зэрэг олон найрагчдын бүтээлүүд гарчээ.

⁷) Д.Сумъяа “Монголын орчин үеийн яруу найраг-I. Хөгжлийн түүх” 2009. 50-57-рт.

⁸) Д.Сумъяа “Монголын орчин үеийн яруу найраг-II”, “О.Дашбалбарын яруу найргийн бурханы шашны үзэл баримтлал” 2009. 152-рт

⁹) Сумъяа Д. “Монголын орчин үеийн яруу найраг-II”. “О.Дашбалбарын яруу найргийн бурханы шашны үзэл баримтлал”. 2009. 152-153-рт

Туульсын зохиолын үг хэллэг, дүр дүрслэл, агуулга багтаамж энэ үед бичгийн зохиолд зохих тусгалаа олж байсан. Өөрөөр хэлбэл орчин үеийн яруу найраг тэр тусмаа эхэн үе нь ардын аман зохиолын шууд уламжлалаас ангид байсангүй. Гэхдээ ардын аман зохиолыг шууд хуулбарлаагүй юм. Харин баяжуулж шинэчилжээ. Энэ нь Ц.Дамдинсүрэнгийн үлгэр өгүүллэгээс эхлээд, сүүл үеийн алдартай найраглалууд хүртэл уламжлал шинэчлэлийн нягт холбоо харуулна. Энд Ч.Лхамсүрэн, Д.Цэвэгмэд, Д.Пүрэвдорж, Ш.Сүрэнжав гээд найрагчдын бүтээлийг нэрлэж болно. Гэхдээ энэ туульсийн хэлбэр эдүгээ цагийн найраглал болохдоо өөрийн их өвөрмөц арга хэлбэрийг олжээ. Жишээ нь улс төр иргэний нийтлэл уянгын бие даасан том төлөөлөгч урлах, дүрслэх авъяасын үлгэр болсон Ц.Гайтавын “Дамдины Сүхбаатар” найраглал 1950-аад оны сүүлээр түүхэн хүнийг уран зохиолд бүтээх, дүрслэх талаар үлгэр болсон юм. Ер нь монгол болон дорнын уран зохиолд намтар зохиол хэмээх уран зохиолын биеэ даасан том төрөл зүйл байдаг. Үүнд түүхэн хүний амьдрал, түүхэн үйлсийг намтар зохиол болгон бичдэг эртний уламжлалтай. Ц.Гайтав авъяас билгийн сэтгэлгээний үест энэхүү арга туурвилыг уламжлан баяжуулж, өнөө нэгэн хүний намтар дээр нийт улс нийдмийн түүх, түүхэн хөгжлийг тохож нөмөргөж гаргасан¹⁰ нь агуулгын багтаамж өргөн, гүн сэтгэмжтэй болгожээ. Энэ нь нийт монгол улс үндэстний хувь заяаны ирээдүйн их үйлс, хувирал хувьслын гүн ухааны аясыг хөндсөн уянгын өвөрмөц дуу хоолой болов.

Монгол ахуй соёлын шим хөрсөнд европын арга барилыг суурьшуулж, уянгын **шүлгийг уран санаа, уянгын** дүрслэлээр нээхэд нийт найрагчид анхаарч байв. Тухайлбал, Н.Нямдорж, Д.Нямаа, Б.Лхагвасүрэн, Д.Цоодол гээд олон яруу найрагчдын бүтээл хамаарна. Яруу найрагч Д.Цоодолын дуулиуд нь хөдөө дайдын эгэл малчин монголын уран дүрийг яруу найрагт оруулж ирсэн юм. Нүдэнд харагдах мэт танил энэ олон янз дүрийг урласан цаад учир нь яруу найрагч хүмүүний үндсэн мөн чанар болох “өрөөлийн зовлоор зовж байдаг” өрөвч нигүүлсэхүй сэтгэлээс үүдэлтэй учир хиймэл, хээнцэр биш, уран тод дүр болсон байна.

Б.Лхагвасүрэн монгол ёс заншил, ардын уламжлалт зан үйл, аж төрөхүй, амьдралын ухаарал, дорно дахины уран сайхны уламжлалт дүр дүрслэл, тэр бүрийг шүлгийнхээ уран санаа саналга, дүр дүрслэл болгож чадсан юм. Энэ нь түүний шүлгийг ухааны хаттай, монгол эр хар ухааны буурь энтэй болгодог.

Монголын орчин үеийн яруу найрагт эх хэлээ эрхэмлэх санаа бүхий шүлэг нэлээд бий. Энэ нь зөвхөн хэл гэсэн утга бус энэ улс үндэстэн оршин тогтнохын үндэс нь эх хэл байна¹¹ гэжээ. Нөгөөтэйгүүр яруу тансаг, цэцэн цэлмэг, уран дүр дүрслэлийн тулгуур илэрхийлэл нь шүлэг зохиолыг бүтээж байгаа эх хэл аж. Иймд эх хэлээ хайрлаж гэсэн хуурай лоозон биш жинхэнэ үгийн дархчууд үгээ хэлээ эрхэмнэсэн нэг төв санаа аж. Энэ үеийн нэг өөр нэг ололт бол монголын казак хэлт, монголын герман хэлт¹² шүлэг найраг бий болжээ.

¹⁰⁾ Сумъяа Д. “Монголын орчин үеийн яруу найраг-I. Хөгжлийн түүх”. 2009. 42-рт.

¹¹⁾ Д.Сумъяа “Монголын орчин үеийн яруу найраг-II”, “Эх хэлний тухай шүлгүүдийн нэг санаа” 2009. 50-рт

¹²⁾ Б.Мөнхбаяр “Монголын уран зохиолын тайлбар толь” 2011. 580, 582-рт

Мөн Монголын орчин үеийн яруу найргийн **өөр нэг онцлог** нь цаг үеэ тусгахад байв. Энэ нь яруу найргийн хурц дайчин, мэдрэмтгий чанартай нь холбоотой. Олон найрагчийн шүлэг зохиолыг нэрлэж болно. Тухайлбал Ш.Дулмаагийн шүлгийн төлөөлөл болгон авч үзэж болно. Ш.Дулмаа нэгэн насаа яруу найрагтай холбосон онцлогтой, түүнийг он цагийнх дагуу үзвэл ХХ зууны II хагасын монголын яруу найргийн түүхэн туурвил зүйн жишээг тодорхой харж болно. Хэзээ ажилчны сэдэвтэй шүлэг, хэзээ энх тайван, хүүхэд эхчүүдийн сэдэв, хэзээ ардчилал шинэчлэлийн үзэл, дуу хоолой чанга хүчтэй байсан тэр цаг үе бүхэнд тэр сэдвээр Дулмаагийн алдартай шүлгүүд нь бичигджээ. Ш.Дулмаа найрагчийн шүлгийг Монголын ХХ зууны II хагасын яруу найргийн төлөөлөл гэх үүднээс үзэхэд энэ үеийн монгол яруу найргийн туурвил зүйн түүхийг төлөөлж чадах нь тодорхой юм. Энэ утгаараа Ш.Дулмаа монголын орчин үеийн яруу найргийн түүхийг тодоор бүтээгч төлөөлөгчийн нэг¹³ байна.

Энэ үеийн яруу найраг нь цаг үеэ хэдий тусгах түүнээсээ уран сайхны нээлт эрлийг байнга эрж олсон байдаг. Жишээ нь Ш.Дулмаагийн “Хүүгийн эцэгт бичсэн захидал” нь нэгэн ядар эмэгтэйн тухай үглэл биш. Харин элбэрэл ачлалын шүлгийн өвөрмөц нэг хувилбар хэлбэр юм. Учир нь бид аав ээжээ магтаж хайрлан хүндэлсэн олон сайхан дуу мэднэ. Үр хүүхдийн зүгээс аав ээждээ ачлал элбэрэл өргөсөн байхад Ш.Дулмаагийн шүлэгт эргээд нөгөө талаас үр хүүхэддээ аав ээж нь байх тэр үүргийн үүднээс элбэрэл хайрын дуу болсон юм. Бидний сайн мэдэх “Танихгүй эмэгтэйн захидал” алдарт зохиол бий. Энэ зохиолд огт танихгүй эмэгтэйн дотоод сэтгэлийг нээж өгчээ. Ш.Дулмаагийн шүлэгт танихгүй хүний сэтгэл зүрхийг биш харин маш ойр, өөрийнх хань нь асан хүн одоо болилоо гээд явчихад утас дээс шиг дураар таслаад хамж биш, орхиод явсан ч тасардаггүй эцэг эхийн /мөнхийн холбоонд/ мөн чанарт амьдралын тэр гүн утгыг шүтэлцүүлэн нээжээ.

Өмнө нь эхлэл төдий байсан орчин цагийн **сэтгэл зүйн бодрол бясалгалын** дүрслэлтэй шүлгүүд 1970-аад оны сүүлч 1980-аад оны дунд үеэс бүр үзэгдэл болж орж иржээ. Энэхүү шинэ сэтгэлгэ, шинэ туурвилын салхийг хагалагч, түүчээлэгч гол үүдэн туурвигч нь Д.Урианхай юм. Түүний анхны бүтээл “Бид дотоод шаталтын хөдөлгүүр” гармагц монголын уран зохиолд шуугиан авчирсан билээ. Одоо ч тэр монголын уран зохиолыг шинэчлэгч тэр тусмаа нүүдлээс суурин иргэншилд шилжсэн, шилжиж буй ард түмний дотоод сэтгэл зүйг нээх эрэлхийлэн, түүнийгээ бэхжүүлж, өнөөдөр монголын уран зохиолын реалист бус сэтгэлгээний гол төлөөлөгчийн нэг гол төлөөлөл болгов.

ХХ зууны яруу найрагчид цаг үеийн хүлээс үзэл суртлын дарамтад ихээр өртөж иржээ. Үүнд ХХ зууны эхэнд үед Д.Нацагдорж, Б.Буяннэмэх зэрэг яруу найрагчид амь насаа хэлмэгдэн алдсан бол, ХХ зууны II хагаст үзэл суртлын шалгуурт зарим яруу найрагчид шахагдаж авъяас билэг нь задарч бүтээл туурвил нь чөлөөтэй хөгжиж цэцэглэж чадаагүй юм. Үүнд Н.Нямдорж, Р.Чойном, Т.Галсан зэрэг олон найрагчид байна. Шүлэг зохиолыг нь үзэж байхад Н.Нямдоржийг Горькийн сургууль төгсөж ирсэн тэр л хэмжээнд нь тогтоогоод зогсоочихсон харагддаг. Энэ авъяаслаг яруу найрагч цаашаа задарч өөрийгөө дахин шинээр нээсэн бол ямар гайхалтай бүтээлүүд гарах байсныг өнөө хэлэх аргагүй. Р.Чойном тэр цагийн үзэл сурталтай улаан нүүрээрээ

¹³⁾ Д.Сумъяа “Монголын орчин үеийн яруу найраг-II”, “Сайхнаас сайн үүднэ Шагдарын Дулмаа” 2009. 47-р

тулж зөрчилдсөөр байгаад өнгөрчээ. Энэ үеийн үзэл суртлын цавчуураас өөрийн ухаан билгийн хүчээр зайлж чадаад, уран туурвилын өөр гарц хайж олсон яруу найрагчийн нэг бол Д.Пүрэвдорж юм. Тэрээр Чингис (яг үнэндээ сэдэв чөлөөлөгдөж үзэл суртлаас ангижирсан ч одоо хүртэл энэ шүлгийг давах Чингисийн тухай шүлэг гараагүй санагддаг-Д.С) зэрэг шүлгээсээ болж үндэсний үзэлтэн гэгдэж, зарим зохиол нь хэвлэгдэхгүй болоход тэрээр ахин өөр гарц олж, алдартай уянгын найраглалуудаа туурвиж монголын орчин үеийн яруу найргийг баяжуулжээ. Үүнийг дурдсан учир нь улс төрийн ийм үзэл суртал, цаг үе, нийгмийн хяхалт хавчлагыг бас хувь яруу найрагч өөрийн билгийн хараагаар өөр гарц эрж олж, өөрийн уран бүтээлээ туурвиж, өөрийн амь нас хийгээд уран бүтээлийн хувьд дахин цэцэглэх боломж буй зэрэг арвин их түүхэн туршлагыг манай утга зохиолын түүх өөртөө тод шингээжээ.

Монголын орчин үеийн яруу найраг нэлээд судлагдсан ч онцлог түүхэн цаг үеийн бүтээлүүд нь цагаа дагаад тодорч судлагдсаар байна. 1930-аад, 1960-аад, ерээд оны уран бүтээл нь шинэ цаг үетэй хамт шинэ хүчтэй давалгаа авчирсан тэр л онцлогоороо судлаачдын анхааралын төвд байж, найрагч хийгээд уран бүтээл нь зохих үнэлгээгээ авсаар байна. 1970-аад оныхон нь соцреализмын аргыг бүрэн төгс бэхжүүлж, өөрөөр хэлбэл энэ үеийн найрагчид юуг ямар аргаар хэрхэн туурвиж, хаана юунд хүрэхээ тод харж байсан бөгөөд тэр зам нь тодорхой байсан тул, зорьсондоо бүрэн хүрч чадсан юм. Иймээс энэ үеийн бүтээлүүд судлагааны хүрээнд бүхэлдээ хамрагдаж чадсан гэж үзэж болно.

Харин хорь, дөч, тавь, наяд оны зохиол бүтээл төдий л сайн нарийн судлагдаж чадаагүй байна. 1920-оод оны яруу найргийг аман зохиолын уламжлалтай агуулгын шинэчлэл бүхүй хувьсгалын дуунууд байна гэж тодорхойлсхийж үлдээгээд, дөч тавиад оныхны бүтээл төлөөлөгчдийн хэмжээнд үнэлэлт авсан боловч тэр цаг үеийнхэн эргэлзэж байсан тул бүрэн дүүрэн судлагдаагүй он цагийн салхинд бүүдийн бүдгэрч үлдсэн тал бас байна. Шинэчлэлийн эхэн салхийг урин дуудаж өөрчлөлтийн үүдийг нээсэн 1980-аад оныхны бүтээл 1990-ээд оноор таслагдан үлдэж төдий л судалгааны хүрээнд ороогүй байна.

Түүхэн үйл явдал орчин үеийн яруу найраг, уран зохиолд хэрхэн дүрслэгдэж байсан зэргийг архивын болон бодит баримтад тулгуурласан голчтой судалгааг гүнзгийрүүлж, түүхэн үнэн гажуудаж байсан хэтийдлийг залруулах¹⁴, орчин үеийн яруу найргийн уран сайхны сэтгэлгээг монголын эртний уран зохиол, бүддийн гүн ухаан, дорно дахины бүс нутгийн уламжлал шинэчлэлийн өргөн хүрээнд нь судалгаа чиглэгдвэл нийт монгол уран зохиолын хөгжиж ирсэн түүх зөв гарах юм.

Монголын орчин үеийн яруу найргийн сүүлийн 21 жилийн гол ололт нь алив үзэл суртал, сэдэв, измийн хүрээнд шахагдаж хашигдахгүй яруу найрагчид өөр өөрийнхөө өнгө төрхөөр бичиж туурвихад чиглэж байна. Өөрөөр хэлбэл аль нэг сэдэв, дүр дүрслэл рүү хошуурч ханардаг энэ үзэгдлийг орхих боломж нөхцөл бий болов.

Гэхдээ өнөөдөр яруу найраг хөгжих боломж бага болов. Нэгд, дунд сургуульд утга зохиол үзэх хичээлийн цаг хасагдсан, хоёрт, зохиолч яруу найрагчдын эдийн засгийн

¹⁴⁾ С.Байгалсайхан (доктор Sc.D, проф). “Толбо нуур” туужийн түүх уран сайхны асуудалд. Олон улсын монголч эрдэмтдийн 10-р их хурал. 2011 он.

бодит хөшүүрэг үгүй болов. Аливаа улс үндэстний орших нэг гол ХИЛ бол үндэсний хэл, утга зохиолын хэл болой. Энэ үндэсний хэлийг хадгалах сан, хөгжүүлэгч хүч нь зохиолч, уншигч хоёр билээ. Энэ үүднээс үндэсний утга зохиолын хөгжлийг дэмжих төр засгийн бодлого байх учиртай.

Дүгнэлт:

Монголын орчин үеийн яруу найраг нь уламжлалын өөрийн арвин их туршлага дээрээ хүн төрөлхтний нийгэм цаг үеийн дэвшилтэд шинэлэг ололт амжилтыг тусган авч өөрийн уран сайхны сэтгэлгээгээр баяжуулан хөгжиж ирэв. Үүнийхээ дүнд монголын яруу найраг нь өнөөдөр нэгэнтээ дэлхий дахины уран сайхны сэтгэлгээний эн төвшинд хэдийнээ хүрчээ.

Ингэхдээ Монголын орчин үеийн яруу найраг нь хөгжлийнхөө зуу шахам жилд олон амжилт олж, мөн олон алдаа дутагдал гаргаж, түүнээ гэтлэн давж, бас нэлээдгүй саад бэрхшээлийг даван туулж, хөгжлийн зүй зохистой жамаараа хөгжиж иржээ.

Яруу найргийн охин тэнгэр Янжинлхам бурхан ивээг.

НОМ ЗҮЙ

- Байгалсайхан С. ХХ зууны монгол өгүүллэгийн туурвил зүй. Улаанбаатар. 2010 он.
- Болормаа Д. Монгол утга зохиолын судлал шүүмжлэлийн ном зүй (1970-2000). Улаанбаатар. 2010 он
- Галбаатар Д. Урлахуйн галыг бадраагч зул, эндүүрлийн гэмийг гэмийг арилгагч зул. Улаанбаатар. 2006 он
- Галбаяр Г. ХХ зууны Монголын уран зохиолын хөгжлийн үе шатууд. Улаанбаатар. 2004 он
- Байгалсайхан С., Сумъяа Д., Болормаа Д. Монгол уран зохиолын дээж бичиг. Улаанбаатар. 2011 он.
- Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх (1921-1965). Улаанбаатар, 1968 он
- Монголын орчин үеийн уран зохиолын түүх (1921-1940). Улаанбаатар, 1985 он, Тэргүүн боть.
- Монголын орчин үеийн уран зохиолын түүх (1941-1960) Улаанбаатар, 1989 он, II боть.
- Монголын орчин үеийн уран зохиолын түүх (1961-1980) Улаанбаатар, 1997 он, III боть.
- Мөнхбаяр Б. Монголын уран зохиолын тайлбар толь. 2011он.
- Сампилдэндэв Х. Монголын орчин үеийн уран зохиолын түүхэн сургамж. Улаанбаатар, 1999 он
- Сумъяа Д. Монголын орчин үеийн яруу найраг-I, Хөгжлийн түүх. Улаанбаатар, 2009 он

- Сумъяа Д. Монголын орчин үеийн яруу найраг-II, Дөрвөн улирал монгол яруу найраг хоёр. Улаанбаатар, 2009 он
- Хүрэлбаатар Л. Дуун утгын яруу зохист. Улаанбаатар, 2005 он
- Хүрэлбаатар Л. Сонгодог уламжлал монгол яруу найраг. Улаанбаатар, 1989 он
- Цэнд Д. Монголын орчин үеийн уянгын яруу найраг (1921-1970) Улаанбаатар, 1972 он
- Цэдэв Д. Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл. Улаанбаатар, 1974 он
- XX зууны монгол зохиолчид (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг монголын зохиолч яруу найрагчдын намтар, уран бүтээлийн товчоо)
- Явуухулан Б. Түүвэр зохиол. “Утга зохиолын тухай” Улаанбаатар, 1990 он, боть II.

SUMMARY

Mongolian modern poetry gained lots of achievements by overcoming some failures and barriers during its development process. Today, Mongolian modern poetry has already reached the level of artistic view of the world.